

## <Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэсний дараах сөрөг

### урвалын тухай зааварчилгаа> (몽골어)

#### Энэ тохиолдолд яах вэ?

- Вакцин тариулсаны дараа тарилга хийлгэсэн хэсэг хавдаж өвдөх тохиолдолд **цэвэрхэн хуурай алчуур тавиад дээр нь мөсөн жин** тавьна
  - Вакцин тариулсаны дараа бага зэргээр халуурах тохиолдолд, ус сайн ууж амрах шаардлагатай.
  - Вакцин тариулсаны дараа халуурах, булчин өвдөх зэргээр бие өвдөх тохиолдолд **халууны эм өвчин намдаагч** ууна.
- \* Урьдчилан сэргийлэх тарилга хийлгэхээс өмнө ацетаминофен(acetaminophen)ий орцтой халууны эм өвчин намдаагч бэлдэх, бие тамирдах зэрэг шинж тэмдэг илэрвэл халууны эм болон өвчин намдаагч ууна уу.

#### Энэ тохиолдолд эмчид хандана уу.

- Вакцин тариулсаны дараа тарилга хийлгэсэн хэсэг **хавдах, өвдөх, салгалах(таталт өгөх)** зэрэг шинж тэмдэг 48 цаг өнгөрсөн ч сайжрахгүй байх тохиолдолд
- Вакцин тариулсаны дараа 4долоо хоногийн дотор **амьсгал давчдах, цээж өвдөх, гэдэс/хэвлий байнга өвдөх, хөл хөөх зэрэг шинж тэмдэг** илрэх тохиолдолд
- Вакцин тариулсаны дараа хүчтэй эсхүл 2 өдрөөс дээш толгой байнга өвдөж **өвчин намдаагч эм үйлчлэхгүй байх тохиолдол болон нүд харанхуйлах тохиолдолд**
- Вакцин тариулсаны дараа **гэнэт тамир тэнхээ алдарч энгийн үеэс өөр гаж шинж тэмдэг мэдрэгдэх тохиолдолд**
- Вакцин тариулсаны дараа тарилга хийлгэсэн хэсэгээс өөр газар **хөхрөх цус алдалт** үүсэх тохиолдолд

#### Энэ тохиолдолд 119 руу утасдаж түргэн тусламжын тасаг руу очно уу.

- Вакцин тариулсаны дараа **амьсгал давчдах** хүчтэй **толгой эргэх** тохиолдолд
- Вакцин тариулсаны дараа **уруул, нүүр хавдах** бүх биеэр хүчтэй **тууралт** гарах тохиолдолд
- Вакцин тариулсаны дараа гэнэт **ухаан алдаж унах** тохиолдолд

<Орчуулгыг Данүри 1577-1366 хийв>

